



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261885 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ц.Энхжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: [enkhjargalts@audit.gov.mn](mailto:enkhjargalts@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.3 Албан шаардлага .....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.УЛАМ-ӨРНӨХ  
ТАНАА

2022.02.25 № 07/398  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,505,700.00</b>	<b>615,256,296,586.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>12,397,795,198.47</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>12,397,795,198.47</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>12,397,795,198.47</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	12,397,795,198.47
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,505,700.00</b>	<b>602,858,501,387.53</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,505,700.00</b>	<b>5,699,500.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,778,500.00	5,169,500.00
35470	Бусад хангамжийн материал	727,200.00	530,000.00
35600	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	602,852,801,887.53
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,420,161,401.32</b>	<b>2,388,931,295.83</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,420,161,401.32</b>	<b>2,388,931,295.83</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>945,482,941.32</b>	<b>933,230,475.83</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,799,999.40	121,799,999.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,079,999.86)	(52,259,999.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,170,835,112.88	1,688,695,861.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(382,310,203.52)	(886,596,960.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	144,128,423.20	140,463,423.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(68,890,390.78)	(78,871,848.17)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,474,678,460.00</b>	<b>1,455,700,820.00</b>
39301	Программ хангамж	37,955,280.00	37,955,280.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,488,820.00)	(28,466,460.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,446,212,000.00	1,446,212,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>617,645,227,881.83</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>617,645,227,881.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>617,645,227,881.83</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>617,645,227,881.83</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	2,422,667,101.32
51220	Тайлант үеийн үр дүн	2,422,667,101.32	615,222,560,780.51
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>617,645,227,881.83</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,190,382,787.03</b>	<b>617,360,043,319.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,140,086,732.78</b>	<b>349,622,776,901.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,140,086,732.78</b>	<b>349,622,776,901.00</b>
120009	Бусад орлого	12,506,500.00	20,794,963,612.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	15,104,310.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,127,580,232.78	328,812,708,978.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,050,296,054.25</b>	<b>267,737,266,418.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,484,764,400.00</b>	<b>267,252,075,425.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	923,060,900.00	1,009,201,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	561,703,500.00	266,242,873,825.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>565,531,654.25</b>	<b>485,190,993.50</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	565,531,654.25	485,190,993.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,767,715,685.71</b>	<b>2,137,482,538.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,767,715,685.71</b>	<b>2,137,482,538.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,046,818,120.89</b>	<b>1,701,403,231.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>521,770,885.85</b>	<b>719,899,520.35</b>
210101	Үндсэн цалин	404,628,127.85	550,576,932.34
210102	Нэмэгдэл	80,661,157.00	123,324,793.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,481,601.00	45,997,794.76
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,776,884.19</b>	<b>89,029,561.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,526,059.12	61,857,195.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,416,390.32	6,960,041.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,255,832.74	5,389,953.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,063,958.51	1,347,488.32
210205	Эрүүл мэндийн даатгал	10,514,643.50	13,474,882.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136,859,400.00</b>	<b>136,859,400.00</b>
210304	Байрны түрээс	136,859,400.00	136,859,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,143,917.39</b>	<b>38,392,724.53</b>
210401	Бичиг хэрэг	11,132,140.00	10,161,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,833,600.00	3,258,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,720,527.39	11,400,074.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,457,650.00	13,573,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,870,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	2,870,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,895,702.00</b>	<b>65,929,290.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,587,300.00	6,950,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	0.00	188,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	407,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	33,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,308,402.00	58,349,330.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>269,501,331.46</b>	<b>651,292,735.49</b>
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	379,000.00	303,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	269,122,331.46	650,989,435.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>720,897,564.82</b>	<b>436,079,307.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,900,000.00</b>	<b>4,300,000.00</b>

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,900,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	4,300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>717,997,564.82</b>	<b>431,779,307.19</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,714,262.57	32,38,393.69
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг – нэмэлт	562,283,302.25	399,380,913.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>615,222,560,780.51</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)</b>	<b>2,422,667,101.32</b>	<b>615,222,560,780.51</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	<b>2,422,667,101.32</b>	<b>2,422,667,101.32</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	<b>2,422,667,101.32</b>	<b>2,422,667,101.32</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	<b>2,422,667,101.32</b>	<b>2,422,667,101.32</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0.00	0.00	<b>2,422,667,101.32</b>	<b>2,422,667,101.32</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	615,222,560,780.51	615,222,560,780.51
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	<b>617,645,227,881.83</b>	<b>617,645,227,881.83</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,062,802,554.25</b>	<b>288,521,553,133.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,506,500.00</b>	<b>20,784,286,715.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,506,500.00</b>	<b>20,784,286,715.40</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	0.00	<b>15,104,310.00</b>
120009	Бусад орлого	12,506,500.00	20,769,182,405.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	15,104,310.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,050,296,054.25</b>	<b>267,737,266,418.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,484,764,400.00</b>	<b>267,252,075,425.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	923,060,900.00	1,009,201,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	561,703,500.00	266,242,873,825.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>565,531,654.25</b>	<b>485,190,993.50</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	565,531,654.25	485,190,993.50
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,501,099,054.25</b>	<b>1,489,686,903.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,501,099,054.25</b>	<b>1,489,686,903.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>780,201,489.43</b>	<b>1,053,607,596.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>521,770,885.85</b>	<b>719,899,520.36</b>
210101	Үндсэн цалин	404,628,127.85	550,576,927.19
210102	Нэмэгдэл	80,661,157.00	123,324,798.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,481,601.00	45,997,794.76
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,776,884.19</b>	<b>89,029,561.42</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,526,059.12	61,857,195.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,416,390.32	6,960,041.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,255,832.74	5,389,953.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,063,958.51	1,347,488.32
210205	Эрүүл мэндийн даатгал	10,514,643.50	13,474,882.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136,859,400.00</b>	<b>136,859,400.00</b>
210304	Байрны түрээс	136,859,400.00	136,859,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,649,617.39</b>	<b>31,777,274.53</b>
210401	Бичиг хэрэг	12,910,640.00	13,552,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,833,600.00	3,258,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,720,527.39	11,400,074.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,184,850.00	3,566,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,870,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	2,870,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,895,702.00</b>	<b>75,738,540.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,587,300.00	6,950,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	188,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	407,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	33,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,308,402.00	68,158,580.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>379,000.00</b>	<b>303,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	379,000.00	303,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>720,897,564.82</b>	<b>436,079,307.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,900,000.00</b>	<b>4,300,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,900,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	4,300,000.00

<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>717,997,564.82</b>	<b>431,779,307.19</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	562,283,302.25	32,398,393.69
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг - нэмэлт	155,714,262.57	399,380,913.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>561,703,500.00</b>	<b>287,031,866,230.40</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>561,703,500.00</b>	<b>274,634,071,031.93</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>561,703,500.00</b>	<b>274,634,071,031.93</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>561,703,500.00</b>	<b>274,634,071,031.93</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	561,703,500.00	274,634,071,031.93
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(561,703,500.00)</b>	<b>(274,634,071,031.93)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	0.00	<b>12,397,795,198.47</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,397,795,198.47

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00		
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>267,277,901,600.00</b>	<b>267,234,781,341.31</b>	<b>43,120,258.69</b>	100.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,009,201,600.00</b>	<b>991,907,516.31</b>	<b>17,294,083.69</b>	98.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,004,901,600.00</b>	<b>987,607,516.31</b>	<b>17,294,083.69</b>	98.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>727,910,800.00</b>	<b>719,899,520.36</b>	<b>8,011,279.64</b>	98.9
210101	Үндсэн цалин	562,738,400.00	550,576,927.19	12,161,472.81	97.8
210102	Нэмэгдэл	113,197,400.00	123,324,798.41	(10,127,398.41)	108.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,975,000.00	45,997,794.76	5,977,205.24	88.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>98,267,900.00</b>	<b>89,029,561.42</b>	<b>9,238,338.58</b>	90.6
210201	Тэтгэврийн даатгал	69,151,500.00	61,857,195.70	7,294,304.30	89.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,279,100.00	6,960,041.43	319,058.57	95.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,823,300.00	5,389,953.11	433,346.89	92.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,455,800.00	1,347,488.32	108,311.68	92.6
210205	Эрүүл мэндийн даатгал	14,558,200.00	13,474,882.86	1,083,317.14	92.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136,859,400.00</b>	<b>136,859,400.00</b>	<b>0.00</b>	100.0
210304	Байрны түрээс	136,859,400.00	136,859,400.00	0.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,821,700.00</b>	<b>31,777,274.53</b>	<b>44,425.47</b>	99.9
210401	Бичиг хэрэг	13,552,000.00	13,552,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,258,600.00	3,258,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,444,500.00	11,400,074.53	44,425.47	99.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,566,600.00	3,566,600.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,738,500.00</b>	<b>9,738,460.00</b>	<b>40.00</b>	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,950,000.00	6,950,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	188,900.00	188,900.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	407,800.00	407,760.00	40.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,300.00	33,300.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,158,500.00	2,158,500.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>303,300.00</b>	<b>303,300.00</b>	<b>0.00</b>	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,300.00	303,300.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,300,000.00</b>	<b>4,300,000.00</b>	<b>0.00</b>	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,300,000.00</b>	<b>4,300,000.00</b>	<b>0.00</b>	100.0

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	4,300,000.00	0.00	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>266,268,700,000.00</b>	<b>266,242,873,825.00</b>	<b>25,826,175.00</b>	100.0
22000 1	Барилга байгууламж	266,268,700,000.00	266,242,873,825.00	25,826,175.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>267,277,901,600.00</b>	<b>267,234,781,341.31</b>	<b>43,120,258.69</b>	100.0
<b>35</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>267,277,901,600.00</b>	<b>267,219,677,031.31</b>	<b>58,224,568.69</b>	100.0
31000 1	Улсын төсвөөс санхүүжих	267,277,901,600.00	267,219,677,031.31	58,224,568.69	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0.00	<b>15,104,310.00</b>	(15,104,310.00)	
<b>35000 1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих</b>	0.00	15,104,310.00	(15,104,310.00)	
	Тохируулгын өөрчлөлт		12,397,795,198.47		
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		12,397,795,198.47		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>108</b>	<b>108</b>	0.00	100.0
61000 1	Төсвийн байгууллага	<b>54</b>	<b>54</b>	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	0.00	100.0
62000 1	Удирдах ажилтан	49	49	0.00	100.0
62000 2	Гүйцэтгэх ажилтан	4	4	0.00	100.0
62000 3	Үйлчлэх ажилтан	<b>54</b>	<b>54</b>	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>485,190,993.50</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>85,810,080.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>85,810,080.00</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>85,810,080.00</b>
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		85,810,080.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>399,380,913.50</b>
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		399,380,913.50
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>485,190,993.50</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>485,190,993.50</b>
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		485,190,993.50

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад байгууллагын даргаар цалинг батлуулан олгож байх, шатахуун зарцуулалтын тооцоог хийх, автомашины шилжилт хөдөлгөөнийг хийлгүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/80 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь Шадар сайдад мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх, ил тод, нээлттэй, шилэн тендер шалгаруулалтын үйл ажиллагаа явуулдаг Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Төрийн худалдан авах ажиллагааны үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулж, тайлагнах;
- Төрийн өөрийн концессын зүйлийн жагсаалт боловсруулах, батлах, уралдаант шалгаруулалт зохион байгуулах;
- Улсын хэмжээний төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх, цахим худалдан авалтыг боловсронгуй болгох;
- Худалдан авах ажиллагаа болон концессын тухай хуультай холбогдох асуудлаар эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх;
- Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Хууль, эрх зүй, хяналт, дотоод аудитын нэгжээс “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн биелэлт, Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. Тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,767,715.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,677.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад тайлант онд материаллаг дүнтэй концессын хөрөнгө шилжин ирсэнтэй холбоотойгоор санхүүгийн тайланд их хэмжээний өөрчлөлт орсон тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1.0 хувиар буюу 2,672,779.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.



### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 615,222,560.8 мянган төгрөгөөр буюу 254.9 дахин өсөж, материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материалын дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	12,397,795.2	12,397,795.2
Бараа материал	2,505.7	602,858,501.4	602,855,995.7
Үндсэн хөрөнгө	2,420,161.4	2,388,931.3	(31,230.1)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,422,667.1</b>	<b>617,645,227.9</b>	<b>615,222,560.8</b>
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,422,667.1	617,645,227.9	615,222,560.8
Засгийн газрын оролцоо	2,422,667.1	617,645,227.9	615,222,560.8
Хуримтлагдсан үр дүн	2,422,667.1	617,645,227.9	615,222,560.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр өмчийн дүн</b>	<b>2,422,667.1</b>	<b>617,645,227.9</b>	<b>615,222,560.8</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 12,397,795.2 мянган төгрөг байгаа нь Үндэсний хөгжлийн газраас шилжиж ирсэн концесстой холбоотой захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 9,184,146.5 мянга, тайлант хугацаанд суутган авсан чанарын баталгааны барьцаа 1,937,648.7 мянга, концессын төлбөрийн үлдэгдэл 1,276,000.0 мянган төгрөг;
- Бараа материалын дансны үлдэгдэл 602,858,501.4 мянган төгрөг болж өссөн нь 6 нэр төрлийн 328,218,730.9 мянган төгрөгийн концессын хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан, 274,634,071.0 мянган төгрөгийн концессын санхүүжилт хийсэн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,388,931.3 мянган төгрөг болж буурсан нь Засгийн газраас худалдан авах ажиллагааг бэхжүүлэх төслийн хүрээнд ADB олон улсын байгууллагаас 599,949.3 мянган төгрөгийн 99 ширхэг тоног төхөөрөмж авч, 19,810.0 мянган төгрөгийн дотоод сүлжээний тоног төхөөрөмж бэлтгэсэн, 79 нэр төрлийн 105,563.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 545,425.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд 266,268,700.0 мянган төгрөг баталсан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,198,682.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 82,273.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 46,541.6 мянган төгрөг,

урсгал шилжүүлгийг 21,746.0 мянган төгрөг бусад зардлыг 32,955.5 мянган төгрөг, нийт 183,516.5 мянган төгрөгөөр зардлыг бууруулж, 1,015,166.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, урсгал санхүүжилтийг 5,964.7 мянган төгрөгөөр бууруулан 1,009,201.6 мянган төгрөгөөр өөрчлөн баталжээ.

Тухайлбал, хангамж, бараа материалын зардлыг 3,774.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 2,114.6 мянган төгрөгөөр бууруулсан нь голлон нөлөөлсөн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд зориулан 267,277,901.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 267,252,075.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 15,104.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хөрөнгийн зардалд 266,242,873.8 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 991,907.5 мянган төгрөг, нийт 267,234,781.3 мянган төгрөгийг зарцуулж, 32,398.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 267,234,781.3 мянган төгрөг буюу 43,120.3 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийг 17,249.6 мянган төгрөгөөр хэмнэсэн, хөрөнгийн зардлыг 25,826.2 мянган төгрөгийг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70418	Худалдан авах ажиллагаа	267,277,901.6	267,234,781.3	43,120.3	100.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,004,901.6	987,607.5	17,294.1	98.3
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4,300.0	4,300.0	0.0	100.0
1.3	80919	Концессоор хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	266,268,700.0	266,242,873.8	25,826.2	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд цахим тендерийн хураамж 485,191.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, мэдээлэл, технологийн үйлчилгээнд 85,810.1 мянган төгрөгийг зарцуулж, 399,380.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “ТЕЗ нарын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо

хэмжээний үзүүлэлт"-ээр Төрийн худалдан авах ажиллагааны газрын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлт батлагдаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу авсан судалгаанд анхаарал татсан асуудал гараагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар "Төрийн худалдан авах ажиллагааны газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баталсан байна. НБББББ-т байгууллагын нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах үе шат, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий болон тусгай бодлого, горимуудыг нарийвчлан тусгасан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 13 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь нийт 563,481,778.2 мянган төгрөгийн 198 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 37,200,619.2 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдаж, акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй болно.

Мөн аудитаар Уул уурхай, маталлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээнд заасны дагуу концессын төлбөр 1,276,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлого дансанд төвлөрүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Үндэсний хөгжлийн газраас шилжиж ирсэн захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгааны барьцаа хөрөнгө, концессын хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудал анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 602,856,060.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 602,852,801.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,258.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 3,258.6 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 2,672,779.0 мянган төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналтай холбоотой 602,852,801.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 274,634,071.0 мянган төгрөгийн ашиглагч байгууллагад шилжүүлэх хөрөнгө, 6 нэр төрлийн 328,218,730.9 мянган төгрөгийн концессын хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэснийг эргэлтийн хөрөнгөд бүртгэж залруулав.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Орлогын данстай холбоотой асуудал

###### 1.1 Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлтээр 485,191.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.2 "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо" гэж заасантай нийцэхгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлтээр бий болж байгаа орлогын төлөвлөгөөг төсвийн саналд тусгаж, батлуулах талаар зөвлөмж хүргүүлэв.

###### 2. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

###### 2.1 Илрүүлэлт:

Байгууллагын даргаар 3-12 дугаар сарын олгохоор тооцсон цалинг батлуулаагүйгээр нийт албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 4 "Цалингийн тооцооны карт" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын даргаар цалингийн тооцооны картыг батлуулан албан хаагчдын цалинг олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### **3. Тээвэр шатахууны зардлын данстай холбоотой асуудал**

#### **3.1 Илрүүлэлт:**

Тайланд онд 2 автомашинд 3,258.6 мянган төгрөгийн шатахуун олгосон бөгөөд автомашины зарцуулах жишиг нормыг баримталж шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 4 "Жолоочийн тооцооны хуудас", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Автомашинд олгосон шатахууныг Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг баримтлан сар бүр тооцоог бодох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### **4 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

#### **4.1 Илрүүлэлт:**

Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй улсын дугаар бүхий Hyundai Sonata DN8 маркийн автомашины шилжилт хөдөлгөөнийг хийгээгүй, өөр байгууллагын нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **4.2 Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашины тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийлгэж, автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Акт, албан шаардлага, зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:							
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал														
1	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	2021 онд ногдох концессын төлбөр 1,276,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	Концессын төлбөр 1,276,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.	1	1,276,000.0			1	1,276,000.00				
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй.	Жилийн эцсийн санхүүгийн тайланг тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэх.	1	0.0					1	0.0		
3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлуулаагүй.	Үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлтээр бий болж байгаа орлогын төлөвлөгөөг төсвийн саналд тусгаж, батлуулах.	1	0.0							1	0.0
4	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Байгууллагын даргаар цалинг батлуулаагүйгээр нийт албан хаагчдын 3-12 дугаар сарын цалинг тооцож олгосон.	Байгууллагын даргаар цалингийн тооцооны картыг батлуулж олгох.	1	0.0							1	0.0
5	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Шатахуун зарцуулалтын тооцоог автомашины зарцуулах жишиг нормыг баримталж хийгээгүй.	Автомашинд олгосон шатахууныг Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан	1	3,258.6							1	3,258.6

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

				жишиг баримтлан тооцох.										
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй Hyundai Sonata DN8 маркийн автомашины шилжилт хөдөлгөөнийг хийлгээгүй.	Санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашины тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийлгэж, автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах	1	0.0							1	0.0
7	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Концессын 602,852,801.9 мянган төгрөгийн концессын хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэсэн.	Концессын хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэснийг эргэлтийн хөрөнгөд бүртгэж залруулав.	1	602,852,801.9	1	602,852,801.9						
Дүн					7	604,132,060.5	1	602,852,801.9	1	1,276,000.0	1	0.0	4	3,258.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Төрийн худалдан авах ажиллагааны газар	АХГ-2022/161/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд 37,200,619.2 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах	1	0.0							1	0.0
Дүн					1	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.0
Нийт дүн					8	604,132,060.5	1	602,852,801.9	1	1,276,000.0	1	0.0	5	3,258.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 175/А0150058

Улаанбаатар хот

АУГ-2022/161/НБ-СТА-ТМЗ  
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эдийн засгийн хөгжлийн яам 2014 онд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг нэр бүхий компанитай байгуулсан байна. Тус гэрээний дагуу концессын зүйлийг ашигласны төлөө 2021 онд ногдох концессын төлбөр 1,276,000,000.00 төгрөгийг тус агентлагийн дансанд шилжүүлснийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.11 "Концесс эзэмшигч нь концесс ашигласны төлөө Эрх бүхий этгээдэд концессын төлбөр төлнө", 2.14 "Концесс эзэмшигч нь концессын үлдэгдэл төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 дахь жилээс эхлэн төлөх бөгөөд Концессын хугацаанд тэнцүү хэмжээгээр Эрх бүхий этгээдийн заасан дансанд санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор төлнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант онд ногдох концессын төлбөр 1,276,000,000.0 /Нэг тэрбум хоёр зуун далан зургаан сая/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 3 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Улам-Өрнөх, ахлах нягтлан бодогч Б.Мөнхзул нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
9019120396 \\10.10.10.20\Bkchig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-30.Docx

001050110





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 176/А 0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/161/НА-СТА-УЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Улам-Өрнөх, ахлах нягтлан бодогч Б.Мөнхзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109  
10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-186.Docx  
9019120396

0010000005

